

ХӨМРӨГ ҮҮСГЭГЧИЙН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖАГСААЛТ

Д/д	Огноо	Нэрийн өөрчлөлт
1.	Нийслэлийн Засаг даргын 1995 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/137 тоот захирамж	“Улаанбаатар-Ус” Улсын үйлдвэрийн газар
2.	Нийслэлийн засаг даргын 2005 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 101 тоот захирамж	“Усны барилга байгууламж” Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газар

Нэг. ХӨМРӨГ ҮҮСГЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

“Улаанбаатар-Ус” НӨҮГ нь анх нь Нийслэлийн Засаг даргын 1995 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/137 тоот захирамжаар байгуулагдсан.

Монгол-Японы Засгийн газрын хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар Улаанбаатар хот орчмын ундны усны нөөц тогтоож, ашиглалтыг сайжруулах Төслийн усны эрэл хайгуул, шинжилгээ материал боловсруулалтанд ашиглаж байгаад Монголын талд хүлээлгэж өгсөн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байдаг.

Тусламжийн машин тоног төхөөрөмж багаж хэрэгслийг Улаанбаатар-Ус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан ашиглах нь зүйтэй гэж үзэн Нийслэлийн Засаг даргын 1995 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/102 тоот захирамж гарч эдгээрийн хариуцан ашиглах байгууллагуудад хувиарлан өгсөн.

Дараа нь Нийслэлийн Засаг даргын 1995 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/137 тоот захирамж гарч анх Ус суваг ашиглалтын газарт хуваарилагдсан өрөмдлөгийн машин техник, туслах тоног төхөөрөмжийг Улаанбаатар-Ус НӨҮГ-т шилжүүлэн өгснөөр нийт 16 нэр төрлийн 594,7 сая төгрөгийн хөрөнгөтэй болсон.

Нийслэлийн Засаг даргын А/137 тоот захирамжийг үндэслэн Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 1995 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн Б/33 тоот тушаалаар Чойжав овогтой Ганболдыг “Улаанбаатар-Ус” НӨҮГ-ын захирлаар томилон ажилуулсан.

1995-1997 он хүртэл “Улаанбаатар-Ус” НӨҮГ-ын захирлаар Ч.Ганболд, зөвлөх инженер П.Адилбиш, нягтлан бодогч Оюун, өрмийн мастер Ц.Мөнхбат, жолооч Зундуй улирлын чанартай туслах ажилчинтай үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд тус хугацаанд III, IV цахилгаан станцуудыг хэрэглээний усаар хангаж байжээ.

Үйл ажиллагааны гол чиглэл нь:

1. Гүний өрөмдмөл худаг гаргах
2. Геологи-гидрологийн хайгуул хийх

3. Худгийн засвар үйлчигээ хийх

Туул голын эргээр байрладаг худгуудын цэвэрлэгээ засварын ажлыг иж бүрэн хийсэн. Мөн ундны усны зориулалтаар 70 м хүртэл гүнтэй цооног 4 ш-ийг өрөмдөж ашиглалтанд оруулсан.

Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 1997 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн Б/32 тоот тушаалаар Ч.Ганболдыг “Улаанбаатар-Ус” НӨҮГ-ын захирлын үүрэгт ажлаас чөлөөлж Дагва овогтой Бэгзсүрэнг мөн өдрөөс томилон ажиллуулсан байна.

1997-2001 он хүртэл захирал Д.Бэгзсүрэн, инженер Б.Эрдэнэчулуун, нягтлан бодогч Ж.Адьяа, өрмийн мастер Ц.Мөнхбат, Ц.Доржсүрэн, жолооч Д.Ванчиндорж, нярав П.Цэцэгээ зэрэг үндсэн 7 ажилчинтай мөн улирлын чанартай туслах ажилчид авч ажил үйлчилгээ явуулж иржээ.

Энэ хугацаанд 100 м хүртэл гүнтэй хайгуулын цооног 5 ш, Булган аймгийн Сансарт ундны усны зориулалтаар хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад 6 ш цооног өрөмдөж ашиглалтанд оруулсан. 2000 оны намар Яргайтад цооног өрөмдөж байгаад өрмийн машин эвдэрч зогссон.

Тус байгууллага нь 1998 онд 11396,0 мянган төгрөг, 1999 онд 86103,0 мянган төгрөг, 2000 онд 51327,8 мянган төгрөгийн тус тус алдагдалтай ажиллаж байжээ.

Захирал асан Д.Бэгзсүрэн нь 2001 оны 04 дүгээр сард нас барсан тул Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2001 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 107 тоот тушаалаар Сэмбэрүү овогтой Төмөрбаатарыг Нийслэлийн Засаг даргын захирамж гартал “Улаанбаатар-Ус” НӨҮГ-ын захирлын үүрэг гүйцэтгэгчээр түр томилон ажиллуулсан байна.

2001 оны 05 дугаар сараас 2002 оны 03 сар хүртэл захирал С.Төмөрбаатар, ерөнхий инженер Б.Эрдэнэчулуун, инженер гидрогеологич Ц.Иванов, нягтлан бодогч Ж.Адьяа, өрмийн мастер Ц.Мөнхбат, Н.Саранчимэг, нярав Баянжаргал, жолооч Д.Ванчиндорж, туслах ажилчин Ж.Чинбаатар, Санчир нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байв.

Энэ хугацаанд үндсэн ажил бараг хийгдээгүй худгийн шавхалт, засварын ажил хийгдэж байсан. Учир нь 2000 оны намаор өрмийн машин эвдэрч засварлагдаагүй.

Захирал С.Төмөрбаатар нь энэ байгууллагын өр авлагыг барагдуулж гадуур тараагдсан эд хөрөнгийг татан авах ажилд гол анхаарлаа чиглүүлэн ажиллажээ.

Нийслэлийн Засаг даргын 2002 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 74 тоот захирамжаар “Улаанбаатар-Ус” НӨҮГ-ын захирлаар Ёндон овогтой Батболдыг томилон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны балансын гадуур бүртгэлтэй байсан Улаанбаатар хотын борооны ус татан зайлуулах насос станцын 228,726 мянган төгрөгийн эд хөрөнгөтэй “Ариутгах татуурга” ХХК-тай “Улаанбаатар-Ус” НӨҮГ-ыг нэгтгэн ажиллуулахаар шийдвэр гарсан байна.

“Улаанбаатар-Ус” НӨҮГ нь анх байгуулагдахдаа Усны бодлогын хүрээлэнгийн байранд:

1. Хашбулаг хайрхан ХХК-ийн байранд 1997 оны 08 дугаар сараас 2001 оны 05 дугаар сар хүртэл
2. Олон улсын геологийн экспедицийн байранд 2001 оны 05 дугаар сараас 2002 оны 04 дүгээр сар хүртэл байрлаж байгаад

2002 оны 04 дүгээр сараас Баянгол дүүргийн 20-р хороо Энхтайваны өргөн чөлөөнд байрлах өөрийн байр болох Борооны болон хөрсний ус татан зайлуулах насос станцын байранд ирж үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн Засаг даргын 2002 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 302 тоот захирамжийн дагуу Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2002 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 263 тоот тушаалаар Нийслэлийн нийтийн зориулалттай нийт 6002633445 / зургаан зуун сая хоёр зуун жаран гурван мянга дөрвөн зуун дөчин тав / төгрөгийн хөрөнгийг бүртгэж хүлээн авсан байна.

Үүнээс балансаас балансад шилжин ирж байгаа 233097700 төгрөгийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан ажиллах үүрэг даалгавар өгөгдсөн байна.

2002 оны 03 дугаар сарын 01-нээс тус байгууллага нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн өмчийн харилцааны газрын шийдвэрийг удирдлага болгон Улаанбаатар хотын ерөнхий менежерийн удирдлаган дор Захирагчийн ажлын албаны харьяанд Нийслэлийн 6 дүүрэгт байрлах:

1. Борооны ус зайлуулах инженерийн шугам сүлжээ, хүлээн авах шүүрт болон үзлэгийн худгийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, арчилгаа, ашиглалт хамгаалалт

2. Үерийн хамгаалалтын далан суваг, гадаргуугийн ус зайлуулах барилга байгууламжийн ашиглалт хамгаалалт, цэвэрлэгээ, арчилгаа, засвар үйлчилгээг хариуцах
3. Усны нөөцийг нэмэгдүүлэх, ундны усны зориулалтаар гүний цооног өрөмдөх
4. Гидрогеологийн судалгаа, хайгуул хийх чиглэлээр ажил үйлчилгээг явуулж ирлээ.

2002 онд үндсэн чиглэлийн борооны болон хөрсний ус татан зайлуулах инженерийн шугам сүлжээ, хүлээн авах шүүрт болон үзлэгийн худгийн арчилгаа цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, үерийн хамгаалалтын далан сувгийн үзлэг шалгалт, арчилгаа цэвэрлэгээг мэргэжлийн байгууллагын үндсэн дээр хийж ирлээ.

Мөн өөрсдийн хүч хөрөнгөөр 8х6 м-ийн хэмжээтэй тоосгон барилга барин конторын зориулалтаар ашиглаж байна. 2003 онд 2 жил гаруй зогссон өрмийн машиныг засварлаж ашиглалтанд оруулж 30-110 м-ийн гүнтэй 3 цооног өрөмдөж ашиглалтанд өгсөн. Насос станцын тоног төхөөрөмжийг засварлаж ердийн ажиллагаатай болгосон ба барилгын дээврийг шинэчлэн засварлав.

“Улаанбаатар-Ус” НӨҮГ нь 2003 онд 16 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан байна.

Нийслэлийн Засаг даргын 2005 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 22 дугаар захирамжаар “Улаанбаатар-Ус” НӨҮГ-ыг “Усны барилга байгууламж” НӨҮГ болгон өөрчилсөн. Энэ өөрчлөлтөөр 7 хүртэл үүнээс 1 удирдлагатай байна гэж удирдлагын орон тоог хязгаарласан. 2005 онд 17 хүний бүрэлдэхүүнтэй ажил үйлчилгээг явуулж байсан.

2010 онд 27 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

2010 онд Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн хөрөнгөөр баригдсан усан оргилуур бүхий цэцэрлэгт хүрээлэнг ашиглалтанд хүлээн авч түүний байнгын ажиллагааг хангаж, тус цэцэрлэгт хүрээлэнд усан оргилуурын техникч 2 , тасалбар түгээгч, үйлчлэгч 1, жижүүр 3 нийт 6 түр болон байнгын ажлын байр гарган ажиллаж байна.

2010 онд тус байгууллага нь 14719,1 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд жилээс жилд орлого, ашгийн санхүүжилтийн үзүүлэлт өсөж байна.

2011 онд тус байгууллага нь 301 526.9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 2 177 806.4 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, нийт 2 479 333.2 мянган төгрөгийн хөрөнгөтэй байна.

2011 онд Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 392 жилийн ой, “Хөдөлмөр эрхлэлт-Хүний хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд тус байгууллагын хийсэн томоохон хөрөнгө оруулалттай ажлуудын нэг бол Хан-уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан Биокомбинатын үерийн хамгаалалтын далан барих ажил юм.

Тус байгууллага нь Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай Хан-Уул дүүргийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлалтай Биокомбинатын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар шинэчлэлт “Элс барих байгууламжтай авто зам доорх ус гаргалгаа бүхий үерийн байгууламж-1” ажлыг хоёр жилийн хугацаанд хийж дуусгахаар гэрээ байгуулан ажиллаж амжилттай дуусгалаа.

Биокомбинатын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлыг тус байгууллага нь 2010 оны 9 дүгээр сараас эхэлж хийсэн бөгөөд Монгол улсад анх удаа шинэ технологиор баригдсан үерийн хамгаалалтын байгууламж юм. Уг үерийн хамгаалалтын байгууламжийн үндсэн далангийн габион доторлогоог 5 үетэй 630 у/м, элс баригчийг 4,5 м өндөр габион доторлогоотой хийж 2 талын ханыг 1240 м² эко хавтангаар бүрж хийж дуусгасан. Биокомбинатын далангийн барилга байгууламжийн ажлыг тус байгууллагын хамт олон 2011 оны 10 дугаар сарын 11-ний өдөр техникийн болон улсын комисст амжилттай хүлээлгэж өглөө.

2011 онд тус байгууллагын захирал Ё.Батболд Ардын Хувьсгалын 90 жилийн ойн медаль, “Нийслэлийн тэргүүний ажилтан”. “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол, тэмдэг, нярав С.Нямсүрэн Ардын Хувьсгалын 90 жилийн ойн медаль, “Хөдөлмөрийн Хүндэт медаль”, “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол тэмдэг, жижүүр Ч.Гимлай, жолооч С.Шаравсамбуу нар Ардын Хувьсгалын 90 жилийн ойн медаль, инженер Ч.Цэнхэрцэцэг НИТХ-ын “Хүндэт үнэмлэх”, жолооч Ш.Бямбасамбуу, засварчин Д.Идэрсайхан, жижүүр Т.Амгалан, инженер Б.Дэлгэрмаа нар Улаанбаатар хотын ерөнхий менежерийн “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнагдав.

Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 392 жилийн ойг тохиолдуулан байгууллага маань ажлаараа дүүрэгтээ шалгарч Баянгол дүүргийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдлаа.

Мөн 2011 онд идэвх санаачлагатай сайн ажилласан 18 ажилтнаа “Тэнгэрийн аялал” ХХК-тай гэрээ байгуулан БНХАУ-ын Эрээн, Бээжин хотуудаар аялууллаа.

Монгол улсын Засгийн газраас 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс “Хөдөлмөр эрхлэлт-Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулж тус байгууллагаас зардлыг нь бүрэн хариуцаж, 4 ажилчинг мэргэжлийн сургалтанд хамруулж гагнуурчин, тогооч, эксковаторчин, сантехникийн засварчны мэргэжил эзэмшүүлж мэргэжлийн зэргийг нь дээшлүүллээ.

2011 онд Нийслэлийн Мэдээллийн технологийн газар, “Супер гравидион” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулан байгууллагын цахим хуудас хийлгэлээ.

2012 онд тус байгууллага нь захирал , ерөнхий инженер, насос станцын инженер, далан сувгийн инженер, шугам сүлжээний инженер, хүний нөөц, архив, бичиг хэргийн мэргэжилтэн, нярав, тогооч, сахиул, үйлчлэгч, цахилгаанчин, жижүүр 3, жолооч 9, засварчин 5 нийт 28 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2012 онд тус байгууллага нь захирал, ерөнхий инженер, насос станцын инженер, далан сувгийн инженер, шугам сүлжээний инженер, хүний нөөц, архив, бичиг хэргийн мэргэжилтэн, нярав, тогооч, сахиул, үйлчлэгч, цахилгаанчин, жижүүр 3, жолооч 9, засварчин 5 нийт 28 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2013 онд нийт 65 болж өссөн.

2013 оны 09 дүгээр сарын 04-ны Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн №100 тогтоол, 2013 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/846 захирамжыг үндэслэн “Усны барилга байгууламж” НӨҮГ-ын даргын Б/74 тоот тушаалаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор “Усны барилга байгууламж” НӨҮГ-ын ажилтан албан хаагчдыг 2013 оны 09 дүгээр сарын 09-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлж шинээр байгуулагдаж буй “Нийтийн Үйлчилгээний Улаанбаатар Нэгтгэл” Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоот Үйлдвэрийн газарт шилжүүлсэн.

Хоёр. ХӨМРӨГИЙН ТҮҮХ

Анх “Улаанбаатар-Ус” НӨҮГ нь 1995 онд Япон улсын буцалтгүй тусламжийн тоног төхөөрөмжин дээр үндэслэгдэн байгуулагдсан боловч 1995-2002 оны санхүүгийн баримт бичиг 10ш, ирсэн, явсан бичиг, захирлын тушаал тус бүр нэг нэг ширхэг байсан. Үүнээс үзэхэд тус байгууллага баримт бичгээ архивт өгч байгаагүй нь харагдаж байна.

“Улаанбаатар-Ус” НӨҮГ нь 2002 оны 02 дугаар сарын 01-ны 74 тоот Нийслэлийн Засаг дарыгн захирамжаар “Ариутгах татуурга” ХХК-тай нийлсэн.

2003 оноос эхлэн архивын баримтыг цэгцлэн янзалж тусдаа өрөө гарган архивын баримт бичгийг стандартын дагуу хөтлөн ирсэн.

2003 оны архивын улсын үзлэгээр архивын гэрчилгээ авсан. “Улаанбаатар-Ус” НӨҮГ нь Нийслэлийн архивт баримт бичгээ шилжүүлээгүй. “Улаанбаатар-Ус” НӨҮГ 2005 оны Нийслэлийн Засаг даргын 22 дугаар захирамжаар “Усны барилга байгууламж” НӨҮГ газар болгон өөрчилсөн.

2006 онд Хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалтыг 69 хэрэг байхаар ББНШК-ын хурлаар оруулан баталсан. Одоо тус байгууллагад 1997 оноос хойшхи 107 баримт хадгалагдаж байна.

Тус байгууллага нь өөр бусад байгууллага аж ахуйн нэгжээс баримт байхгүй, хосгүй үнэт болон үнэт баримт байхгүй өөрийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бүртгэн авч байгаа.

Баримт бичигт устгал одоогоор хийгдээгүй байна. 2005 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Захирлын А-4 тоот тушаалаар баримт бичиг нягтлан шалгах комиссыг томилсон.

2004 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “Улаанбаатар ус” НӨҮГ-т олгогдсон 060044 тоот архивын гэрчилгээг 2010 оны 03 дугаар сарын 25-ны өдөр “Усны барилга байгууламж” НӨҮГ болгон өөрчилж 37 тоот архивын гэрчилгээ шинээр олгосон.

2011 онд Нийслэлийн Засаг даргын 2011.03.24-ны өдрийн 250 тоот захирамжийг үндэслэн архивын баримтанд тооллого хийх ажлын хэсгийг байгууллагын захирлын 2011.05.02-ны өдрийн А/10 тоот тушаалаар байгуулж,

тооллогыг 2011 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийг дуустал явуулж дүн мэдээг Нийслэлийн ажлын хэсэгт гаргаж явууллаа. Цаасан суурьт баримт нийт 476 хадгаламжийн нэгж /ХН/ тоологдсоноос үндсэн үйл ажиллагааны холбогдолтой ХН 382, зураг төслийн ХН 94 байв. 2004-2009 оны огт данс бүртгэлгүй байсан 46 байнга болон түр хадгалагдах ХН-ийн данс бүртгэлийг зохих ёсоор үйлдэж данс бүртгэлтэй болгов. Тусгай төрлийн 2001-2010 оны баримтын хадгаламжийн нэгжийг данс бүртгэлтэй болгож тооллогод хамруулав. Дүрс бичлэгийн 16, гэрэл зургийн цомгийн 18, гэрэл зургийн негативын 5 ХН тоологдов. Тооллогын ажлын хүрээнд архивын баримтыг эмхлэн цэгцэлж данслах ажил хийгдэв.

Захирлын 2011.05.06-ны өдрийн А/12 тоот тушаалаар байгууллагын архивын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг шинэчлэн баталж, 2011.07.20-ны өдрийн А/28 тоот тушаалаар ББНШК-ыг шинээр байгуулав.

2012 оны эхний улиралд 2011 оны хөтлөгдөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан 65 хэргийн жагсаалтын дагуу архивт 111 баримт хүлээн авч дансалсан байна. Тус байгууллага нь тусдаа зориулалтын архивын өрөөтэй бөгөөд баримтаа 2 төмөр сейф, 1 шүүгээнд хадгалж байсан.

Одоогоор байгууллагын архивт хосгүй үнэт, нэн үнэт болон хувийн хөмрөг үүсгэгчийн баримт байхгүй.

Гурав. Хөмрөгийн баримтын тодорхойлолт

2012 оны 07-р сарын 25-ны байдлаар тус байгууллагын архивт 1995-2011 оны цаасан суурьтай баримт нийт 632 хадгаламжийн нэгж /ХН/ байгаагаас үндсэн үйл ажиллагааны холбогдолтой 504 ХН, техникийн зураг төслийн 128 ХН, мөн тусгай төрлийн нийт 42 ХН-ээс гэрэл зургийн цомгийн 21 ХН, дүрс бичлэгийн 16 ХН, гэрэл зургийн негативын 5 ХН хадгалагдаж байсан.

Төрийн архивын үндсэн зааварт заасан архивыг түүх, эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй баримтаар нөхөн бүрдүүлэх, Төрийн архивт баримт хүлээлгэн өгөх хугацаа болсон зэргээс 2012.03.22-ны өдөр Нийслэлийн Архивын газар, “Усны барилга байгууламж” НӨҮГ-тай ЭШТБ-ын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан

ЭШТБ-ын ажлын үр дүнд:

Байнга хадгалах 1995-2009 оны 117 ХН-ийн данс,
70-н жил хадгалах 1997-2009 оны 18 ХН,
Түр хадгалах 2003-2009 оны 160 ХН
Гэрэл зургийн цомгийн 2001-2010 оны 16 ХН,
Дүрс бичлэгийн 2003-2011 оны 16 ХН-ийн бүртгэл

Цаашид эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзэж хадгалах хугацаа нь дууссан 1997-2010 оны 18 хэргийн 64 ХН-ийг устгахаар Устгах хэргийн актыг тус тус үйлдэн Нийслэлийн Архивын газрын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэн батлуулж Төрийн архивт байнга хадгалах 1995-2009 оны 117 ХН, гэрэл зургийн цомгийн 2001-2010 оны 16 ХН, дүрс бичлэгийн 2003-2011 оны 16 ХН, байгууллагын архивт 70 жил хадгалах 1997-2009 оны 18 ХН, түр хадгалах 2003-2009 оны 160 ХН хүлээлгэн өгсөн .

Архивын баримтыг зөвхөн байгууллагын ажилтнуудын хүрээнд ашиглаж байлаа.

2013 оны 09-р сарын 09-нд тус байгууллага нь татан буугдаж нэгтгэл болсонтой холбоотойгоор архивын баримтыг Нийслэлийн Архивын газарт хүлээлгэн өгөх болсон.

Баримтын бүрдлийн хувьд:

Захирлын тушаал, захирлын зөвлөлийн болон ажилчдын хурлын тэмдэглэл, ирсэн, явуулсан бичиг, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бизнес төлөвлөгөө, байнга, түр, 70 жил, дүрс бичлэг, гэрэл зургийн хадгаламжийн нэгжийн данс, бүртгэл, үр дүнгийн гэрээ, хамтын гэрээ, ажлын байрны тодорхойлолт, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын баримт, төсөв, төсвийн хуваарилалт, санхүүгийн баримт, тайлан тэнцэл, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, ажил хүлээлцсэн акт холбогдох баримт, бүртгэл хяналтын карт, бүртгэлийн дэвтрүүд, өргөдөл, гомдол зэрэг баримтаас бүрдэж байсан.

ЭШТБ-ын явцад дараах ажлууд хийгдсэн:

- Баримтын нэр, төрөл, асуудал, сэдэв, хадгалах хугацаа, зохион байгуулалт, огноогоор байнга, 70 жил, түр, устгах хугацаагаар нь ангилан төрөлжүүлсэн.
- Ирсэн, явуулсан бичгийг нягтлан шалгаж ач холбогдолоор нь байнга, түрд авсан.
- Газрын даргын тушаалыг 2010 оноос хойшхи тушаалыг үндсэн үйл ажиллагаа, боловсон хүчний холбогдлоор байнга, 70 жилийн бүртгэлд авсан. Газрын цаг үеийн

шинж чанартай мэдээ, сарын мэдээ зэрэг хадгалах хугацаа дууссан баримтыг ҮЖ-ын заалтаар устгалд авсан.

- **ЭШТБ-ын ажлын үр дүнд:**

- Байнга хадгалах 1997-2012 оны 89 ХН-ийн данс,
- 70-н жил хадгалах 1997-2012 оны 35 ХН,
- Түр хадгалах 2003-2012 оны 290 ХН
- Гэрэл зургийн цомгийн 2011-2012 оны 6 ХН,
- Дүрс бичлэгийн 2002-2006 оны 18 ХН,
- Цаашид эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзэж хадгалах хугацаа нь дууссан 2003-2012 оны 12 ХН-ийг устгахаар Устгах хэргийн актыг тус тус үйлдэн Нийслэлийн Архивын газрын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна.

ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ ҮЙЛДСЭН:

С.ЭРДЭНЭБАТ